



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 09 сарын 05 өдөр

Дугаар №/1099

Улаанбаатар хот

Хөрөнгө оруулалтын ажлыг
зохион байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 2014 оны 5 дугаар сарын 23-ны өдөр соёрхон баталсан Монгол Улсын Засгийн газар, Азийн хөгжлийн банк хооронд 2013 оны 12 дугаар сарын 09-ний өдөр байгуулсан “Гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр”-ийн санхүүжилтийн ерөнхий хэлэлцээр, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 88 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Азийн хөгжлийн банк, Европын Хөрөнгө оруулалтын банкны санхүүжилтээр хэрэгжүүлж байгаа “Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр” төсөл 2-ын хүрээнд МОН-3525 дугаартай зээлийн хэлэлцээрт тусгагдсан нийслэлийн төсвөөс санхүүжүүлэх дэд бүтэц, бүтээн байгуулалтын ажлыг хавсралтаар баталсугай.

2. Энэ захирамжийн хавсралтад заасан төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхэд шаардлагатай 1,500,543,968.00 (нэг тэрбум таван зуун сая таван зуун дөчин гурван мянга есөн зуун жаран найм) төгрөгийг Нийслэлийн 2024 оны батлагдсан төсвийн “Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 оны төсвийн жилд хэрэгжүүлэх барилга байгууламж, төсөл, арга хэмжээний жагсаалт”-ын 130.1-д батлагдсан “Гадаадын зээл, тусламжаар хэрэгжих төслүүдийн нийслэлийн хариуцах хөрөнгө (Улаанбаатар хот)”-өөс гүйцэтгэлээр холбогдох хууль, журмын дагуу хянан баталгаажуулж, санхүүжилтийн эрх нээхийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, хөрөнгө оруулалтын газрын Хөрөнгө оруулалтын хэлтэс (Б.Гантулга)-т, нээсэн эрхийг үндэслэн батлагдсан төсвийн сар, улирлын хуваарийн дагуу санхүүжүүлэхийг Санхүү, хөрөнгө оруулалтын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Л.Эрдэнэбадрах)-т, захиалагчийн хяналт тавьж ажиллахыг “Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр”-ийн төсөл хэрэгжүүлэх нэгж (Д.Авирмэд)-д, хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон хөрөнгийг нийслэлийн өмчид бүртгэн авах ажлыг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Өмчийн харилцааны газар (В.Оюумаа)-т тус тус даалгасугай.

3. Энэ захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын эдийн засгийн хөгжил, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч Н.Мандуулд даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ



Х.НЯМБААТАР

1110204638

Нийслэлийн Засаг даргын 2024 оны
09 дугаар сарын 05-ны өдрийн
Р/2049 дугаар захирамжийн
Хавсралт

“УЛААНБААТАР ХОТЫН ГЭР ХОРООЛЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТЫГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР” ТӨСӨЛ 2-ЫН ХҮРЭЭНД НИЙСЛЭЛИЙН
ТӨСВӨӨС САНХҮҮЖҮҮЛЭХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ,
АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ

(төгрөг)

Д/д	Гэрээний дугаар	Төсөл арга хэмжээний нэр, хүчин чадал,	Эхлэх он	Дуусах он	2024 онд санхүүжих дүн
1	DARI-1&2	Дамбадаржаа дэд төв орчмын дэд бүтцийн барилга угсралтын ажил (DARI-1 багц)	2022	2025	809,316,091.00
2	DARI-1&2	Дамбадаржаа дэд төв орчмын дэд бүтцийн барилга угсралтын ажил (DARI-2 багц)	2022	2025	691,227,877.00
Нийт дүн					1,500,543,968.00